

Төрийн албаны зөвлөлийн  
2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн  
297 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан

шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн  
газар

Нэгжийн нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Эх барих, эмэгтэйчүүд, нярайн  
тусламж үйлчилгээ хариуцсан  
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 11 дүгээр баг,  
төрөх гудамж 113 байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн тухай хууль, төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хүрээнд эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, оношлогоо эмчилгээний стандартыг мөрдөн ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлого, стандартын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах.

2.Эрүүл мэндийн байгууллагуудын эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр хяналт тавьж, мэргэшил арга зүйгээр хангах.

3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

| Зорилт                   | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг                                                                                                                                                                                                                                                                                                    | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт                          | Хариуцлага,оролцооны хэлбэр<br>Туслах - Т<br>Хариуцан гүйцэтгэх – Г<br>Хянах-Х<br>Шийдвэрлэх-Ш |
|--------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|
| 1дүгээр зорилтын хүрээнд | 1.Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний талаар гарсан Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллах;                                                                                                                                                                               |                                                        | Г                                                                                              |
|                          | 2. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх; | Гаргасан шийдвэр тушаалыг хэрэгжүүлэн ажилласан байна. | Г                                                                                              |
|                          | 3.Эх нялхсын эрүүл мэндийн асуудлаар гарсан тушаал, шийдвэр, эмчилгээ оношлогооны стандартаар эрүүл мэндийн байгууллагуудыг хангах, шинэ технологи, тэргүүний туршлага нэвтрүүлэх, эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах, мэргэжлийн арга зүйгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;                    | Гаргасан шийдвэр тушаалыг хэрэгжүүлэн ажилласан байна. | Г                                                                                              |
|                          | 4.Эх нялхсын өвчлөл, эндэгдэл, жирэмсний болон төрөлтийн хүндрэлийн шалтгаан тогтоох судалгааг жил бүр хийж, шийдвэрлүүлэх;                                                                                                                                                                                                           | Судалгааны үр дүн гарсан байна.                        | Г                                                                                              |
|                          | 5.Эх барих эмэгтэйчүүдийн асуудлаа гарсан санал гомдол, шүүмжлэлийг                                                                                                                                                                                                                                                                   | Хугацаанд нь шийдвэрлэсэн                              | Г                                                                                              |



|                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                            |   |
|---------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|---|
|                           | оновчтой шийдвэрлэх, алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах;                                                                                                                                                                                                                                                         | байна.                                                                                     |   |
|                           | 6.Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээний эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилтийг хангуулах.                                                                                                                                                                  | Хяналт үнэлгээ байгууллагуудад хийсэн байна.                                               | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Өөрийн орны болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх;                                                                                                                                                                                                                                        | Үйл ажиллагаа зохион байгуулсан байна.                                                     | Г |
|                           | 2.Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн байдлыг хянах, тайлагнах;                                                                                                                                                              |                                                                                            | Г |
|                           | 3.Аймаг, сум, сум дунд, өрхийн болон хувийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангахад эх баригч, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлж чадавхжуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх; | Мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан байна.                                         | Г |
|                           | 4.Эх барих эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж тулгамдсан асуудлыг тодорхойлон арга хэмжээ авах;                                                                                                                                                                                                             |                                                                                            | Г |
|                           | 5.Эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачлагатай ажиллаж байгаа хамт олон, байгууллагыг урамшуулах, сурталчилах ажлыг зохион байгуулах,                                                                                                                                                                     | Эрүүл мэндийн салбар хоорондын уялдаа холбоо сайжирсан байдал, зохион явуулсан арга хэмжээ | Г |
|                           | 6.Эх, нярайн эрүүл мэндийг хамгаалах төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт-үнэлгээ хийх, үр дүнг тооцох;                                                                                                                                                                                                                 | Хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.                                                    | Г |
|                           | 7.Ард иргэдэд өөрийн хариуцсан ажиллаж байгаа үйл ажиллагаатай                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                            | Г |



|                           |                                                                                                                            |                                                                                              |   |
|---------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|---|
|                           | холбоотой мэдээллээр хангах, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр сургалт сурталчилгаа явуулах;                         |                                                                                              |   |
|                           | 8.Эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлээр судалгаа хийж үр дүнг тооцож ажиллах, бодлого боловсруулах.                           |                                                                                              | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;                                            | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажилласан байна.                                | Г |
|                           | 2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;                                                                              | Ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна.                                                    | Г |
|                           | 3.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; | Албан хэрэг, архив хөтлөлт стандартын дагуу хөтлөгдөж, сайжирсан байна.                      | Г |
|                           | 4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх;                                                    | Шуурхай хэрэгжүүлж, эргэн мэдээлсэн байна.                                                   | Г |
|                           | 5.Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах;                               | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд тайлагнасан байна. | Г |
|                           | 6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;                       |                                                                                              | Г |
|                           | 7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.                                                                   | Чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.                                                              | Г |

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

|           |                                                                                   |
|-----------|-----------------------------------------------------------------------------------|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.                                 |
| Мэргэжил  | Анагаах ухаан /091201/.                                                           |
| Мэргэшил  | Төрийн албанд мэргэшүүлэх богино дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. |
| Туршлага  | Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх                                    |



|              |                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ур<br>чадвар | Дүн<br>шинжилгээ<br>хийх | <ul style="list-style-type: none"> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;</li> <li>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|              | Асуудал<br>шийдвэрлэх    | <ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- бүтээлч, санаачлагатай ажиллах;</li> <li>- бусад.</li> </ul> |
|              | Багаар<br>ажиллах        | <ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй, шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>                                                                                                                                                                                                                                 |
|              | Бусад                    | <ul style="list-style-type: none"> <li>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.</li> </ul>           |



#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:  
Байхгүй .

Бусад харилцах субъект:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны холбогдох ажилтан;
- Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан;
- Эрүүл мэндийн бусад байгууллагууд;
- Төрийн болон төрийн бус байгууллагууд;
- Иргэн, хуулийн этгээд.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,  
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын  
шийдвэр:

Албан тушаал:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо 19 11 04

Дугаар 297

..... Б.НУРЖАЙНАР  
2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо 2019.12.31

Дугаар А/79

(тамга/тэмдэг)

ДАРГА ..... С.АЙГҮЛ

2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр

БҮӨЕ0019

